


## Уур амьсгалын өөрчлөлт ба уул уурхай



### Уур амьсгалын өөрчлөлт ба уул уурхай

Монгол улс газар зүйн байршил, мөн эмзэг экосистемтэй учраас уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг улсуудын нэг юм. Уур амьсгал нь Монгол улсын түүхэн ба өнөөгийн байдлыг тодорхойлж, цаашид ч тодорхойлсоор байна. Манай малчдын ахуй амьдрал байгалийн цаг уурын байдалтай нарийн уялдсан байдаг. Одоогоор нийт газар нутгийн 80 хувь нь уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралтай гамшигт үзэгдэлд эмзэг гэж тооцогдож байна.

Монгол улсын хувьд хөдөөгийн алслагдсан орон нутаг, уул уурхайн үйл ажиллагаа, уур амьсгалын нөхцөл байдал хэрхэн уялдах вэ гэдэг асуудал чухал нөлөөтэй. Мал аж ахуй нүүдлийн хэлбэрээр голдуу явагддаг тул хуурай газар нутагт усны хүртээмж, чанар нь хөдөө орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргаанд маш чухал ач холбогдолтой (Sternberg, 2008). Уул уурхай өргөжиж усны хэрэглээ нэмэгдэхэд нийт усны хэмжээнд төдийгүй мөн усны чанарт ихээхэн нөлөөлнө. Уул уурхай болон холбогдох дэд бүтэц нь малчдад хэрэгцээтэй бэлчээрийн газрыг ашигласнаараа газрын төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлдэг. Энэ нь алсдаа талуудын хоорондын зөрчил, сөргөлдөөний эх үүсвэр болох талтай.

2015 онд Өмнөговь, баянхонгор аймагт болсон "Уур амьсгалын өөрчлөлт ба уул уурхай, уламжлалт аж ахуй" сэдэвт олон талт хэлэлцүүлгийн тоймыг дараах бичлэгүүдээс үзнэ үү.

Өмнөговь аймаг

<https://youtu.be/62bARFUg9OM> <https://youtu.be/D9Pf7oRuyok>

Илүү дэлгэрэнгүйг дараах эх сурвалжаас уншаарай.

*(Sharma, V, Byambajav D, Gerelt-Od, E, Myagmartsooj, Natsag, & Saruulzaya, A. 2016. Traditional Livelihoods and Mining in Mongolia's Changing Climate: Exploring the Potential of Crosssectoral Partnerships in Achieving Sustainability. APN Science Bulletin. Sternberg, T 2008. Environmental challenges in Mongolia's dryland pastoral landscape. Journal of Arid Environments, 72, pp. 1294-1304*